



**“СУРГУУЛИЙН БЭЛЭН БАЙДЛЫН АСУУДАЛ БА ШИЙДЭЛ”
сэдэвт сургалт- онол практикийн бага хурлын удирдамж**

2017.11.10 Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг

Хурлын зорилго:

Боловсрол үндэсний хөтөлбөр, Нийслэлийн боловсрол -2020 хөтөлбөр, “Хүн болох багаасаа” аяны хэрэгжилтийг хангах, албан ба албан бус боловсролын хүрээнд СӨБ болон Бага боловсролын залгамж чанар, багшийн хөгжлийг дэмжих, сургуулийн бэлэн байдлыг үнэлэх, цаашдын чиг хандлагын талаар мэдээлэл, туршлага солилцох боломж бүрдүүлэх

Хамрах хүрээ: Төрийн болон төрийн бус цэцэрлэг, сургуулийн удирдлага, арга зүйч, бага ангийн сургалтын менежер, багш, нийгмийн ажилтан

Зохион байгуулагч : Боловсролын хэлтэс

Хурлын зохион байгуулалт:

- I үе шат 2017 оны 11сарын 10-17-нд /Сургууль, цэцэрлэгт хүүхдийг сургуульд бэлтгэх талаарх эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудал түүнийг шийдвэрлэх арга зам, туршилт судалгаа, 5 ба 6 настай хүүхдийн онцлог, хөгжил хамгаалал, нэгдүгээр ангид дасан зохицох, амжилттай суралцах үндэс, эцэг эхийн оролцоо, хамтын ажиллагааны сайн туршлагаа хэлэлцэх/
- II үе шат 2017 оны 11 сарын 24-нд /Сургуулийн бэлэн байдлын асуудал ба шийдэл сэдвээр илтгэл бичиж хэлэлцүүлэхэд бэлтгэх/
- Хуралд оролцогчдыг бүртгэх: 2017 оны 11сарын 17-ны 10.00 цагт дүүргийн 9 давхрын хурлын жижиг танхимд бүртгэж, холбогдох сургалт зохион байгуулан чиглэл өгч, зөвлөн тусална.
- Сургалтын агуулга нь сургуулийн бэлэн байдлын талаарх ойлголт мэдлэг, шалгуур, багшийн хөгжлийн өнөөгийн чиг хандлага, мэргэжлийн эрэгцүүлэл, хяналт шинжилгээ, судалгаа хийх арга зүйд чиглэгдэнэ.
- Илтгэлийг 2017 оны 11 сарын 24-нд цаасаар буюу хэвлэмэл хэлбэрээр Боловсролын хэлтэс / Л.Сосорбарам / -т хүлээж авна.

Хугацаа: 2017 оны 11сарын 29-нд 9.00 цагт дүүргийн Хурлын их танхимд болно.

Илтгэл бичихэд анхаарах зүйл:

Тус онол практикийн бага хуралд хэлэлцүүлэх илтгэл нь судалгаанд суурилсан, тулгамдсан асуудлыг дэвшүүлж шийдвэрлэх арга замыг тодорхойлсон, түгээн дэлгэрүүлэхүйц, үр дүнд хүрсэн, нотлох баримт бүхий ажил-үйлчилгээ, сайн туршлага зэрэг байх энэ талаар удирдлага, эцэг эх олон нийтийн хамтын ажиллагаа, дэмжлэг үзүүлсэн зэрэг нь давуу тал болно.

Илтгэлд тавих шаардлага:

1. Сэдвийн томъёолол хурлын агуулгад нийцсэн байна.
2. Илтгэлийн сэдвийг том үсгээр А4-ийн хуудас голлуулан бичих ба хуудсыг дугаарлахгүй. Сэдвийн дараах мөрний баруун буланд зохиогчийн овгийн эхний үсэг, нэр, мэргэжил, албан тушаал байх ба ард нь цэцэрлэг, сургуулийн нэрийг нуман хаалтад бичнэ.
3. Илтгэлийн эхэнд хураангуйг догол мөрөөс эхлэн 5-8 мөрөнд багтааж бичих ба 4-6 түлхүүр үгийг мөн догол мөрөөс эхлэн бичнэ.
4. Илтгэлийг ном зүй ба хавсралтын хамт нийт А-4 хэмжээний 5-7 нүүрт багтааж, Times New Roman шрифт, үсгийн фонт 12, давхар (double) мөр хоорондын зайтай, хуудасны дөрвөн талд 1 инч (2.54 см) зай авч бичнэ.
5. Илтгэлийн ишлэл ба ном зүйг оруулахдаа хаалтан дотор зохиогчийн овог, хэвлэгдсэн он, хуудасны дугаар (х.) гэсэн дарааллаар оруулна.
6. Дээрх шаардлагын дагуу бичсэн илтгэлийг сургууль, цэцэрлэг бүрээс тоо харгалзахгүй, хугацаандаа ирүүлээгүй илтгэлийг хүлээж авахгүй болно.

Хүрэх үр дүн: Хүн болох багаасаа аян, Боловсрол үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт эрчимжинэ. Судалгаа, оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан бага насны хүүхэд, эцэг эхийг сургуульд бэлтгэх, тэдэнд зөвлөн туслах, багшийн хөгжлийг дэмжих замаар сургуулийн бэлэн байдлын тогтолцоог дүүргийн түвшинд төлөвшүүлэх шинэлэг ажил үйлчилгээний эхлэл болно.

Болзол:

1. Шалгарсан илтгэлийг байр эзлүүлэн шагнаж урамшуулна.
I байр 1 /Батламж 100000 төг/
II байр 2 /Батламж 80000 төг/
III байр 3 /Батламж 50000 төг/

Удирдамж боловсруулсан: Ахлах мэргэжилтэн Л.Сосорбарам /Ph.D/

Хурал зохион байгуулах комисс